



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 111

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.4, 6.6 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын /Газрын тусгай үйлчилгээний албаны/ үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон, гурван удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй, нийт 38,523,700.00 /гучин найман сая таван зуун хорин гурван мянга долоон зуун/ төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 3 ширхэг автомашиныг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Иргэний нисэхийн ерөнхий газрын Газрын тусгай үйлчилгээний албаны дарга С.Чинзоригт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу Байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Акталж, данснаас хасаж сэлбэгээр худалдсан автомашины улсын дугаарыг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойполт, дээрх арга хэмжээний биелэлтийн хамт 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Наангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

3.МЭНДСАЙХАН


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

D.Нарангэрэл

Д.НААНГЭРЭЛ

00001

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 03 дүгээр сарын 13/-ны өдрийн
111 дугаар тогтоолын хавсралт



Иргэний нисэхийн ерөнхий газрын /Газрын тусгай
үйлчилгээний алба/ үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
акталж, данснаас хасах автомашин

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн ашиглалтад орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	9,800,000.00
1	УАЗ-3909, 12-10 УНП, арал № 37410040413002	2004/ 2004	11,800,000.00	11,800,000.00
2	УАЗ-3909, 74-59 CYA, арал № ХОО331906	2001/ 2001	8,025,000.00	8,025,000.00
3	Ссангъяонг Рэхтон, 48- 92 УБК, арал № KPBFA2AF14P1268	2004/ 2005	18,698,700.00	18,698,700.00
	Нийт дүн		38,523,700.00 /гучин найман сая таван зуун хорин гурван мянга долоон зуун/	38,523,700.00 /гучин найман сая таван зуун хорин гурван мянга долоон зуун/